



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 10 сарын 28 өдөр

Дугаар А/544

Мөрөн сум

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29.2, Төсвийн тухай хуулийн 14.2.2, 14.2.3, 58.2.5 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит бус XIII хуралдааны 01 дүгээр тогтоолыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Монгол хүний насжилтад нөлөөлж буй хүчин зүйлс” эрдэм шинжилгээний бага хуралд амжилттай оролцож 1 дүгээр байранд шалгарсан аймгийн Боловсрол, соёл, урлагийн газрын багт 700,000 төгрөг, 2 дугаар байранд шалгарсан аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн Д.Батцоожид 600,000 төгрөг, 3 дугаар байранд шалгарсан Мөрөн сумын Титэм ерөнхий боловсролын сургуулийн түүх, нийгмийн ухааны багш нарын багт 500,000 төгрөг, Тусгай байранд шалгарсан Эрдэнэбулган сумын ерөнхий боловсролын сургуулийн нийгмийн ажилтан Ж.Лхамноржинд 300,000 төгрөг, тусгай байранд шалгарсан аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн О.Дагиймаад 300,000 төгрөгийг тус тус олгосугай.

2. Дээрх шагналд олгох 2,400,000/ Хоёр сая, дөрвөн зуун мянга/ төгрөгийн хөрөнгийг “Зорилтот бүлгийн иргэдэд нийгмийн хамгааллын үйлчилгээг үзүүлж, амьдрах орчныг сайжруулах” төсөл, арга хэмжээний зардлаас зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө сруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга Э.Аззаяа, Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Г.Базар/ нарт үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Х.Ган-Очир/-д даалгасугай.

ДАРГА

Л.ГАНБОЛД